



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар

A/23

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж, Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
Б.Орбиш (Нийгмийн ажилтан)
Багийн Засаг дарга нар
Шатахуун түгээх станцуудын эрхлэгч нар

2. Сумын нутаг дэвсгэрт галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН